



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/09

Рашаант

Сумын эм эргэлтийн сангийн
бүтэц орон тоо батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.3 дахь заалт, 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 498/345 дугаар тушаал, Эм, эмнэлгийн тухай хууль, “Эм санд тавигдах нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандартыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын MNS:526052015 стандарт Эмийн санд тавигдах нийтлэг стандартын дагуу Эм эргэлтийн сангийн бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахин мөрдөж зохих хууль журмын дагуу бүтэц орон тооны дагуу ажиллахыг Эм эргэлтийн сангийн эрхлэгч (М.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.


3. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Эм эргэлтийн сангийн эрхлэгч (М.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАСРАНДОРЖ

Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 6109 дугаар захирамжийн хавсралт



Эм эргэлтийн сангийн бүтэц орон тоо

Д/д	Албан тушаал	Орон тоо
1	Эм эргэлтийн сангийн эрхлэгч	1
2	Жор баригч	0,5
3	Үйлчлэгч	1